



**МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,
Цахим шуудан: info@energy.gov.mn

2024.07.03 № 2/2045

танай _____-ны № _____-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ КОМПАНИУДАД

Эрчим хүчний яамнаас зарласан “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачаалалд ажиллах тархмал дулааны эх үүсвэр /Улаанбаатар/” төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохоор сонирхож буй компаниас 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн тодруулга асуултын хариултыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт *2* хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА *Н.Тавинбэх* Н.ТАВИНБЭХ



170690001700

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн
даргын 2024 оны 7 дугаар сарын 25-ны
өдрийн 630 тоот албан бичгийн хавсралт



**“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН
ОРГИЛ АЧААЛАЛД АЖИЛЛАХ ТАРХМАЛ ДУЛААНЫ ЭХ ҮҮСВЭР
/УЛААНБААТАР/” ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ**

2024.06.26-нд ИРҮҮЛСЭН ТОДРУУЛГЫН ХАРИУ:

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн 2-р бүлэг, Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй, нэгжийн хүчин чадал 14МВт-иас доошгүй хүчин чадалтай иж бүрэн хийн дулааны станцын барилга байгууламжийн угсралтын ажлыг 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь 1 удаа хийж гүйцэтгэсэн байх” гэж, ТШЗ 19.3-т “0.1–100 МВт болон түүнээс дээш хүчин чадалтай дулааны эрчим хүчний эх үүсвэрийн угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ” гэж тус тус заасан шаардлагуудыг хангаж буй компанийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Оролцогч тендерийн үнийн 20 хүртэл хувийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэхээр санал ирүүлж болно” гэж зааснаар туслан гүйцэтгүүлэхээр санал ирүүлсэн тохиолдолд оролцогчийг ТШЗ 19.1, ТШЗ 19.3-т заасан шаардлагуудыг хангасан гэж үзэх эсэх:

Хариулт: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйл болон тендер шалгаруулалтын зааварчилгаатай сайтар танилцана уу.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн 2-р бүлэг, Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 7.1-д “Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна” гэж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Түншлэлийн гишүүн бүрийн гүйцэтгэх үүрэг тендерийн үнийн 20 хувиас дээш байна” гэж заасан нь түншлэлийн хувьд гишүүдийн тооны дээд хязгаар гүйцэтгэх үүргээс хамаарч 4-өөс ихгүй байх нь зөв эсэх:

Хариулт: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйл болон тендер шалгаруулалтын зааварчилгаатай сайтар танилцана уу.

3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн 2-р бүлэг, Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй, нэгжийн хүчин чадал 14МВт-иас доошгүй хүчин чадалтай иж бүрэн хийн дулааны станцын барилга байгууламжийн угсралтын ажлыг 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь 1 удаа хийж гүйцэтгэсэн байх” гэж заасан шаардлагыг хангах 1-р бүлэг, ТШЗ-ны 11.1-д “Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно” гэж зааснаар дотоодын компани хангах шаардлага тавьж тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой эсэх:

Хариулт: Тус төсөл нь Монгол Улсад өмнө нь хийгдэж байгаагүй шинэ технологи бүхий томоохон хөрөнгө оруулалтын төсөл тул чадавхи болон туршлагын үзүүлэлтийг тендерийн баримт бичигт оруулах боломжгүй.

4. Тендерийн өгөгдөлийн хүснэгтэд заасан Маягт 8, 9, 11 нь 5-р бүлэгт байхгүй байгаа бөгөөд заасан Маягтуудын загварыг өгнө үү

Хариулт: Тендерийн баримт бичгийн 5-р бүлэгт заасан тендерийн жишиг маягтуудад нийцүүлэн хүний нөөцийн мэдээлэл болон үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээллийг маягт 2, маягт 3-ын дагуу ирүүлнэ.

---oOo---